

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал		
Огноо:	2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 11:00-13:10	Уулзалтын газар:	Мэдээлэл холбооны сүлжээ ХКК-ийн байрны 4 давхрын хурлын зааланд хуралдав.
Хурлын дарга:	Содномдовжидын Нямбаяр, МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал		
Тооллогын комисс:	Дарга: С.Цог, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн, Гишүүд: Т.Бямбасүрэн, Бодлого төлөвлөлтийн албаны ерөнхий менежер Б.Хулан, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер		
Ирц:	94.70% (Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,500,087 ширхэг саналын эрх бүхий 8 хувьцаа эзэмшигч оролцов.)		



Оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Овог нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо	Брокерын компани
1	Баттөмөрийн Ганболд	ЖИ85032413	1	БИДИСЕК ҮЦК ХК
2	Магсаржавын Отгонбаяр	ЧЙ65122711	200 300	АРГАЙ БЭСТ ҮЦК ХХК БИДИСЕК ҮЦК ХК
3	Мягмаржавын Шигшээ	ХБ74122819	4	ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК ХХК
4	Раднаабазарын Баасансүрэн	ШЗ356042018	5	АРД СЕКЮРИТИЗ ҮЦК ХХК
5	Сумъяагийн Уранчимэг	УЖ62022600	20	МЭРГЭНСАНАА ҮЦК ХХК
6	Аюурын Чулуун	УС46012050	255	АЛТАН ХОРОМСОГ ҮЦК ХХК
7	Галт-Очирын Батнасан	УС74092001	15	ДАРХАН БРОКЕР ҮЦК ХХК
8	Цэрэрнадмидын Шинэхүү (төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч)	ЖЙ78011470 (ТӨБЗГ- 6098169)	24,499,287	ТӨХ I
	Ирсэн саналын эрхтэй хувьцааны тоо		24,500,087	

ХЭЛЭЛЦСЭН нь:

- Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай, үүнд:
 - Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
 - Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа нэмж гаргах тухай, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай;
 - Олон нийтэд нээлттэй санал болгох хувьцааны тоо ширхгийг тогтоох тухай;
 - Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;

- Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай;
- Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахыг тогтоох тухай;
- Компанийн одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх буюу тусгаарлуулах үүрэг хүлээх тухай;
- Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах тухай;
- Хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;
- Нэмж гаргасан хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрсөн хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг танилцуулах тухай;

2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай;

СОНССОН нь:

С.Нямбаяр, хурлын дарга: Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 192 дугаар хурлын 06 дугаар тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар тогтсон байгаа. Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулна.

С.Цог, Тооллогын комиссын дарга: Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн мэдээлэл 1. Компанийн тухай хуулийн 69.1-д заасан саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор, 2. МЦХ ХК-ийн дүрмийн 7.12-д “компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор

Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг үндэслэн: Ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 24,500,087 ширхэг хувьцаа эзэмшиж буй 8 хувьцаа эзэмшигч ирж 94.7 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна. Тооллогын комиссын дарга С.Цог.

С.Нямбаяр, хурлын дарга: Ирц бүрдсэн тул өнөөдрийн хурлыг эхлүүлье. Хурлаар хэлэлцэх асуудал, хурлыг дэгийг танилцуулъя.

Хурлын дарга хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж, хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай

Хэлэлцэх асуудлаар компанийн Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай танилцуулгыг Инновац, бизнес хөгжлийн газрын захирал Ж.Баасандорж, компанийн дүрмийн төслийн төслийг Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр нар тус тус танилцууллаа.

Ж.Баасандорж: Хувьцаа нэмж гаргах тухай эрх бүхий байгууллагуудын шийдвэрүүд байгаа. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, үүнтэй холбоотой Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 336 дугаар тогтоол тус тус гарсан. Энэ хүрээнд компани нэмж хувьцаа гаргахтай холбоотой асуудлыг журмын дагуу гүйцэтгээд явж байна. Одоогийн байдлаар компанийн нийт 25,870,276 ширхэг хувьцаа байна. Үүнээс 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Эндээс Засгийн газрын хувийг 66.0 хувь байлгаж нэмж хувьцаа гаргаснаар хувьцааны тоо ширхэг 37,120,131 болж үүнээс Засгийн газрын хувьцаа 94.7 хувиас 66 хувь болж бууна, бусад хувьцаа эзэмшигчид 3.7 хувь болж буурна. Ингээд шинээр 30.31 хувь буюу 11,249,855 ширхэг хувьцаа гаргахаар байна. Эндээс Засгийн газрын оролцооны түвшин 28.7 хувиар, бусад хувьцаа эзэмшигчдийн оролцоо 1.6 хувиар тус тус буурах үзүүлэлттэй байгаа. Шинээр 30.3 хувийг эзэмших хувьцаа эзэмшигчид орж ирнэ. Хуульд заасан дүрэм журмын дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүдийг сонгон шалгаруулж ажлууд хийгдээд явж байна. Андеррайтерийн үйлчилгээ “Ти Ди Би Секьюритис” ҮЦК ХХК, Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ “Мөнх-Оргил трейд үнэлгээ” ХХК, Аудитын үйлчилгээ “Өлзийт экаунт аудит” ХХК, Хуулийн зөвлөх үйлчилгээ “Өмгөөллийн соёмбо легал партнерс” ХХН-үүд тус тус сонгосон. Одоо дараах ажлууд хүлээгдэж байна. • МХБ болон СЗХ-нд үнэт цаасны бүртгэлийн багц баримт бичиг хүргүүлэх, • Маркетинг болон танилцуулах аянтай холбоотой бэлтгэл ажлууд бүрэн хийгдсэн байх, /судалгааны ажил явагдаж байна/ • МХБ болон СЗХ-ноос зөвшөөрөл гаргах, • Танилцуулах аян эхлүүлэх, • Анхдагч зах зээлийн арилжааны захиалга авч эхлэх, • Анхдагч зах зээлийн хуваарилалт хийх, • МХБ-ийн дүгнэлт, анхдагч зах зээлийн арилжааны тайланг СХЗ-нд хүргүүлэх, • СХЗ-ноос хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгох, • Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд өмчлөх эрхийн бүртгэл хийгдэж дуусгах, • Хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх эдгээр ажлууд хүлээгдэж байна. Энэ оны 4 дүгээр улиралд багтахтаар төлөвлөгөөт ажлууд хийгдээд явж байна. Бидний урьдчилсан тооцооллоор 2023 оны 12 сарын 10-ны дотор монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцааг арилжаалахаар төлөвлөж байна. Нэмэлт хувьцаа гарган татан төвлөрүүлсэн хөрөнгөөр гол үйлчилгээнүүд дээр гуравласан үйлчилгээ буюу түрүү жилээс хэрэгжүүлж ирсэн, сумдын түвшинд амжилттай хэрэгжиж байгаа Гуравласан үйлчилгээ FTTH сүлжээг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа. Өргөн зурвасын өндөр хурдны гуравласан үйлчилгээний /FTTH/ технологийг шилэн кабелин интернэтийн үйлчилгээ нэвтрээгүй орон нутаг, алслагдсан бүсэд шилэн кабелиар чанартай, хямд өртөгтэй өндөр хурдны интернэтийн болон бусад суурин утас, телевизийн үйлчилгээг хүргэнэ. Мөн FTTH үйлчилгээг өргөжүүлэн компанийн ашиг орлогыг нэмэгдүүлнэ. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өндөр хурдны дэд бүтэц байгуулна. Орон нутагт цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд үйлчилгээгээрээ дамжуулан дэмжлэг үзүүлнэ. Цахим боловсролыг нийгмийн давхаргаас үл хамааран тэгш хүртээмжтэй хүргэнэ. Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлнэ. Сүлжээний хамрах хүрээний гэмтэл

саатал багасаж, найдвартай байдал нэмэгдэнэ. Хоёр дахь зорилго бол хөдөлгөөнт интернэт сүлжээг байгуулахыг зорьж байна. Ингэснээр өндөр хурдны интернэтийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлнэ. Интернэт протоколд суурилсан үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, шинэ үйлчилгээг дэмжих, технологийн нэгдэн нийлэлтийг хангах боломжтой болно. Зах зээлийн дижитал шилжилтийг түргэсгэж, хэрэглэгчдийн дижитал хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой. Зүйлсийн интернэт IoT, бүх төрлийн ухаалаг төхөөрөмжүүдийг интернэтэд холбон удирдах боломжийг олгоно, мэдээж компанид нэмэлт орлого нэмэгдэнэ. Суурин утасны системийг бүтнээр нь шинэчилж, шинэ үеийн IMS гэсэн систем рүү нэвтрүүлэхийг зорьж байгаа. Ингэснээр станцын ажиллагаа, ашиглалт, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна. Нэмэлт үйлчилгээ гарч одоо байгаа үйлчлүүлэгчид шинээр үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой болох юм. Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2023.10.06-ны өдрийн байдлаар хаалтын ханшаар 13,892,338,212 төгрөг байна. 2023 оны 9-р сарын байдлаар арилжааны мэдээллийг графикаар үзүүлсэн. Хувьцааны хаалтын ханш хамгийн бага даа 537, хамгийн өндөр ханш нь 690, хамгийн бага ханш 425 төгрөг байлаа. Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд хамгийн багадаа өдөрт 1 ширхэг, хамгийн ихдээ 1,901 ширхэг, нийт 14,511 ширхэг арилжаалагдсан. Үнийн дүн нийт 8,175,245 төгрөг байна.

Ж.Азбаяр: Нэмэлт гаргах анхдагч арилжаа амжилттай болсны дараа хамгийн анхны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэгдэх компанийн дүрмийн төслийг гүйцэтгэх удирдлагын баг болон андеррайтер, хуулийн үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулсан. Энэ дүрмийн төсөл бол 12 бүлэг 207 зүйл, заалттай. Компанийн дүрмийн төслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвартай нийцэж буйг андеррайтерийн болон хуулийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдээс санал авч, хуульд нийцсэн талаарх дүгнэлт гарсан. Онцлог нь одоогийн 2018 онд батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрмийн төсөлтэй уялдуулж нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар шинэчлэн найруулсан. Гол хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид эрхийг хамгаалах чиглэлээр илүү эрх үүрэг гэсэн бүлгийг дэлгэрэнгүй оруулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр байх ирц компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр байна гэснийг 70-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч оролцсоноор гэж оруулсан.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бүс хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай

Хэлэлцэх асуудлаар тогтоолыг Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр уншиж танилцууллаа.

Ж.Азбаяр: Нэмж хувьцаа байгуулахад андеррайтер, хөрөнгийн үнэлгээ, аудитын үйлчилгээ, хуулийн зөвлөх үйлчилгээ зэрэг мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулж ажилладаг. Эдгээр хүмүүс 6 үнэт цаасны танилцуулгыг хамтран гаргах процесс явагддаг. Энэ процесс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулахгүй асуудал байсан учраас МЦХ ХК-ийн ТУЗ-өөс түр журам баталсан. Энэ журмын хүрээнд ажлын хэсэг байгуулсан. Дээрх дөрвөн хуулийн этгээдүүдийн сонгон шалгаруулсан гээд эдгээр процессууд нь тодорхой хугацаа шаардсан ажлууд байсан. Тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхэд компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зохицуулалтаар нэгдүгээрт хувьцааны үнэ, тоо,

журам эдгээрийг тогтоосны дараа мэдэгдэл хүргүүлдэг. Энэ мэдэгдэл хүргэсний дараа хувьцаа эзэмшигчд ажлын 30 хоногийн дараа хариу өгөхөөр байгаа. Энэ мэдэгдлээ хүргүүлэхдээ Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэж журмын дагуу хүргүүлдэг. Энэ цаг хугацааг тооцоод үзэхээр 2-3 сар шаардахаар байгаа. Хоёрдугаар, нэмэлт хувьцаа гаргасан, ХХК компаниас ХК компани болсон өмнөх туршлагыг харахад энэ тэргүүн ээжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлсэн компани байхгүй байна. Ингээд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоод заасны дагуу 2023 оны дөрөвдүгээр улиралдаа багтаж нэмэлт хувьцаа гаргах ажил маань энэ хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхээр цаг хугацааны хувьд амжих боломжгүй юм байна, нэгдүгээрт. Хоёрдугаарт мэргэжлийн байгууллагууд цаг хугацаа их шаарддаг, үр дүн багатай ажил байдаг юм аа. Нэгэнт УИХ, ЗГ-ыг бодлого бол олон нийтэд нээлттэй болгох, олон нийтийн хяналт тогтооё гэж байгаа бол нэмэлт хувьцаа гаргаж байгаа ажиллагааг олон нийтийг оролцуулах зарчмыг баримталж явуулах нь зүйтэй байна гэж санал болгосноор 2023 оны хоёрдугаар сарын арван тавны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцоод нэмэлт хувьцаагаа гаргах ажиллагааг олон нийт рүү чиглүүлээд явна гэсэн агуулгаар энэ асуудлыг та бүхнийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж оруулж байгаа.

Гуравдугаар хэлэлцэх асуудлаар

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай

Хэлэлцэх асуудлаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, нэр дэвшигчдийн танилцуулгыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Х.Цэцэгмаа: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 сарын 02-ны өдрийн 158, 159 дүгээр тогтоол, 2023 оны 8 сарын 28-ны өдрийн 408, 409 дүгээр тогтоолуудыг үндэслэсэн байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэгчдийг танилцуулъя. Бат-Эрдэмийн Төрбат Монгол улсын Засгийн засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шинжээчээр ажилладаг. 1991 онд Сэлэнгэ аймагт төрсөн. МУИС-ийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2013-2016 онд Монголын хуульчдын холбоонд Туслах, мэргэжилтэн, 2016 оноос одоог хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар шинжээчээр ажиллаж байна. МЦХ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 сарын 23-ны өдрийн 191 дүгээр хурлаас ТУЗ-ийн ердийн гишүүнээр түр томилогдон ажиллаж байгаа. Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргаар ажилладаг. 1979 онд Төв аймагт төрсөн. МУИС-ийг Улс төр судлаач-нийгмийн ухааны багш, АНУ-ын Страйерын их сургууль төрийн удирдлагын менежер мэргэжлээр тус тус төгссөн. 2001-2006 онд МАН-ын сургалт судалгааны хэлтэс, Прогноз төв, эрдэм шинжилгээний ажилтан, 2006-2008 онд МАН-ын сургалт судалгааны хэлтэс, Прогноз төв, дарга, албаны дарга, 2008-2011 онд Нийслэлийн МАН-ын хороо, зохион байгуулалтын хэлтсийн дарга, 2008-2011 онд Нийслэлийн ИТХ дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дарга, 2015-2016 онд МАН, МАН-ын ерөнхий нарийн бичгийн даргын орон тооны зөвлөх, 2016.09 одоог хүртэл ТӨБЗГ, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс болон Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргаар ажиллаж байна. 2016-2020 онд МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж, энэ хугацаандаа ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан. Дээрх тогтоолын дагуу, 2023 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн ТУЗ-ийн 193 дугаар хурлаар ТУЗ-ийн ердийн гишүүнээр түр томилогдсон байгаа. Энэ хоёр гишүүн өнөөдрийн хурлаад ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөхөөр сонгогдохоор нэр дэвшиж байгаа.

С.Нямбаяр, хурлын дарга: Өнөөдрийн хурлаар хэлэлцүүлж байгаа гурван асуудлыг танилцуулж дууслаа. Үүгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үндсэн хэлэлцэх долоон асуудал танилцуулагдаж дууслаа. Хэлэлцэж байгаа асуудлаар асуулт, харилтаа эхлүүлье. Асуулт асуух хүн байвал гараа өгөөд асууна уу.

Асуулт хариулт, санал:

Б.Ганболд: 1. Хувьцааны үнэ тогтоогдсон байгаа юу, 2т үйл ажиллагаанд хөдөлгөөнт интернэт гэж байна интернэтийн төхөөрөмж зараад зах зээлд нэвтрүүлнэ гэсэн үг үү, дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч, дараа нь бид мэдэж байгаа Star link Монголд орж ирэх гээд нэлээн ажлууд явагдаж байгаа. Тэгэхээр энэ компанитай ямар нэг байдлаар холбогдож байгаа юу уу. 5 сард билүү болсон Учрал сайдтай уулзалт дээр олон улсын компанитай МЦХ хамтарч ажиллах боллоо гэж байсан. Энэ ажил маань яаж явж байгаа вэ.

Дүрмийн 8.9 дээр редакцын алдаа гарсан байх шиг байна. 8.9 дахь хэсэгт заасан биш 8.8 дахь хэсэгт заасан гэж засах саналтай. 8.20 дээр хараат бус гишүүн гуравны нэг нь байна гэсэн. Компаниуд ихэнх нь гуравны нэгээс доошгүй гэсэн байдаг. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах үүднээс 5 гишүүн хүртэл байдаг. Тэгэхээр гуравны нэг гээд заачихаар 3 гишүүн байна л гээд байна. Тэгэхээр доошгүй гэсэн үг оруулбал гэсэн саналтай байна.

Ж.Баасандорж: Одоогоор нэгж хувьцааны үнэ тогтоогүй байгаа. Хурлаас шийдвэр гараад андеррайтер компаниас танилцуулга хийсний дараа андеррайтер компаниас үнэ хэлэх байх. Одоогоор тодорхойлох боломжгүй байна. Хөдөлгөөнт интернэт гэж суурин газар, сумд бүгд хөдөлгөөнд үйлчилгээ нэвтэрсэн байгаа. Үүнд бид тухайн орон нутагт хөдөлгөөнт интернэтийн бааз станц байгуулаад хүмүүс дата сим аваад тэр нь өргөн зурвасаар өндөр хурдны интернэт авах, аль болох бага үнээр өргөн зурвасын өндөр хурдны интернэтийн үйлчилгээ үзүүлэхээр судалгаа хийгээд ажиллаад явж байна. Дараагийн асуулт бол Барселон хотод 2 сард Mobile World гээд үзэсгэлэнд оролцсон. Энэ уулзалт дээр One web гээд хиймэл дагуулын интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компанитай холбогдож судалгаа шинжилгээний ажил хийгдэж, хэд хэдэн удаагийн уулзалт, онлайн хурал хийсэн. Өөрсдийн саналаа боловсруулж өгсөн. Одоогоор албан ёсны хариу ирээгүй байна. Star link компанитай ямар нэг холбоо тогтоогоогүй. Star link компанийн өөрийн бодлого нь иймэрхүү провайдер юм уу дамжуулж үйлчилгээ үзүүлдэг ямар нэг компанитай хамтарч ажиллахгүй гэсэн бодлоготой юм билээ.

Б.Ганболд: Цахилгаан холбоо чинь бүх сумд орсон билүү?

Ж.Баасандорж: Яг бүх сумдад биш, 280 сумд байгаа.

Б.Ганболд: Бусад үүрэн компаниуд хөдөлгөөнт интернэт орсон байгаа. Энэ хөдөлгөөнт интернэт нь тэдэнтэй өрсөлдөхүйц даваа тал юу уу байна.

Ж.Баасандорж: Хөдөлгөөнт интернэт дээр үүрэн холбоо GB гээд хэмжээгээр хязгаарлаж байгаа. Бид хэмжээгээр хязгаарлахгүй. Тогтмол үнээр өндөр хурдаар үйлчилгээ үзүүлбэ. Тийм боломж манай байгаа. Сум хүртэл явсан өөрийн хот хоорондын суваг, зарим газраа өөрийн сүлжээг ашиглаж үйлчилгээг хүргэе гэж байгаа. Онцлог гэдэг нь хүмүүс тодорхой мөнгө төлөөд тэр нь дуусаж байгаа тэр нь нэмж авахгүй тухайн сардаа хангалттай хэмжээнд үйлчилгээгээ авах юм.

Р.Баасансүрэн: Зуслангийн бүсэд энэ үйлчилгээ ажиллуулж болох уу? Бусад компанийн “манай интернэт” гэдэг шиг байх уу?

Ж.Баасандорж: Бусад компанийнх шиг төхөөрөмжөөр ашиглаж болно. Нөгөө талд нь гар утсандаа дата сим хийгээд гар утаснаасаа интернэт ашиглаж болно. Аль нь нь ч болно.

М.Отгонбаяр: Компани нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид гээд мэдээллээ тавиагүй байсан. Тэрийг хэзээ тавих вэ? Хоёрдугаарт 2022 оны 4 дүгээр сарын 29, дугаар 16 гээд “Биржээр олон нийтэд нээлттэй худалдах чиглэл батлах тухай” гээд. Үүнд, монгол банк энэ компанид ямар хамаатай вэ?

Ж.Азбаяр: 4 сарын 29-ний өдрийн УИХ-ын тогтоолоор 16 дугаар тогтоолоор банкны хувьчлал, компаниудын хувьчлалыг баталсан. Төрийн өмчит банкнуудын хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалахтай холбоотой асуудлыг Хоёрдугаар хавсралтаар, төрийн өмчит компаниудыг нэгдүгээр хавсралтаар нь баталсан байгаа. Үүнд банк хамаагүй.

Т.Гандулам: Төр 94.7 хувийн эзэмшиж байгаа. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж тухайн компанийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж этгээдийг хэлдэг. Тэгэхээр үлдэж байгаа 5.3 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдээс нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхгүй.

М.Отгонбаяр: Өнгөрсөн өвөл олон 5,000 хувьцаатай хүн байсан.

Т.Гандулам: Тэд бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болохгүй.

С.Нямбаяр: Өөр асуулт асуух хүн байна уу?

Ц.Шинэхүү: Дүрмийн төслийн төслийн танилцуулгыг заавал энэ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулах шаардлагатай байсан уу.

Ж.Азбаяр: Дүрмийн төслийг үнэт цаасны танилцуулгад оруулаад, хөрөнгө оруулагч нар би ийм дүрмээр, ийм эрх үүрэг хэрэгжүүлж, ингэж оролцох юм байна гэдийг заавал танилцуулах андеррайтерийн компанийн шаардлага байсан. Үнэт цаасны танилцуулах баримт бичигт заавал ордог баримт бичиг шүү. Орсон тохиолдолд энэ төслөөс нэг их өөрчлөгдөхгүй Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурлаар батлагддаг.

Ц.Шинэхүү: Дүрмийн зарим нэг заалтуудыг засварлах жишээлбэл ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн заалтад явж байна гэх мэт зүйлүүд байна. Өмнө явж байсан жишиг байна. ТУЗ-ийн гишүүн сонгох асуудал бол Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг асуудал шүү дээ. Тэгэхээр хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх шилжсэн шийдвэр гарахгүйгээр, хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн гишүүнд санал болгоод ТУЗ хуралдаад түр томилоод байгаа юм, энэ болох юм уу? Эрх шилжсэн шийдвэр гарахгүйгээр шууд нөхөн сонгуул гэж байхгүй. ХЭХ хуралд гэхгүй бол

Дээр захирлын асуудлыг хэлсэн. 8.8 руу ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал орсон байна. Энэ дүрмийн төслийг зарим заалтыг харах хэрэгтэй байна. Асуулт асууж, саналаа хэлэх эрхтэй. Дүрэм дээрээ хараад саналаа өгөх хэрэгтэй. Том жижиг хамаагүй. 8.26, 8.27 дээр 7 доошгүй гэх хэрэг байна уу, компанийн тухай хуулийн 78.1 дээр олонхын санал гэж байдаг болохоос 7-оос доошгүй гэж байдаггүй.

Ж.Азбаяр: Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрмийг тодорхой зохицуулалтуудыг тухайлан хөндөх талаасаа биш, Хувьцаа эзэмшигчдийн эрхийг тусад нь зааж өгөх, Хувьцаа эзэмшигчдийн хүчин төгөлдөр ирцийг нэмье. Өөрөөр 2018 онд батлагдсан дүрмийн төслийг оруулсан.

Ц.Шинэхүү: Нэгэнт хөндөж байгаа бол зөвхөн хувьцаа эзэмшигчид биш, ТУЗ-ийн бүрэн эрхийг асуудал, Гүйцэтгэл удирдлагын үүргийг авч үзэх хэрэгтэй. Өмнө явж байгаа дүрэм бусад компаниудын нийтлэг дүрэмтэй нийцэхгүй байгаа. Үүнийг нийцүүлэх хэрэгтэй юу уу

бусад компаниудын нийтлэг дүрэмтэй нийцэхгүй байгаа. Үүнийг нийцүүлэх хэрэгтэй юу уу гэж асууж байгаа. Нэгэнт ажиллаж байгаа болохоор нийтэд нь өөрчлөх юм уу өөрчлөхгүй юм уу?

Ж.Азбаяр: Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн асуудал учраас та саналаа оруулаад явах боломжтой.

Ц.Шинэхүү: За тэгэхээр би саналаа хэлээд явъя. Бусад дүрмээс өөр дүрэм байгаад байгаа. Өмнө дүрмээ өөрчлөх хэрэгтэй гэж хэлж байсан. Хэдэн заалтууд, 8 дугаар бүлэг дээр л өөрчлөлт орж байгаа.

Т.Гандулам: Та саналаа бичгээр өгвөл боломжтой. Үүнд зөвлөх компани татгалзахгүй байх гэж бодож байна.

Ц.Шинэхүү: За.

С.Нямбаяр: Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн саналыг цаасаар аваад, протоколдоо оруулаад явъя. Өөр асуулт, санал байхгүй бол санал хураалтаа эхэлье. Тооллогын комисс саналаа хураана уу.

С.Нямбаяр, хурлын дарга: Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналыг нэгтгээд дүнгээ гаргасан байна. Тооллогын комиссын тогтоолыг Тооллогын комиссын дарга Цог танилцуулна.

Тооллогын комиссын дарга С.Цог санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 24,500,087 ширхэг хувьцаа эзэмшиж буй 8 хувьцаа эзэмшигч оролцож, үүнээс 8 хувьцаа эзэмшигч санал өгсөн бөгөөд хүчингүй саналын хуудас байхгүй.

Саналын хуудсанд 3 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлж, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай 1-р асуудалд;
Зөвшөөрсөн 8 санал, 100 хувиар буюу 24,500,087 ширхэг хувьцаа;
Татгалзсан санал байхгүй;
2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай 2 дугаар асуудалд;
Зөвшөөрсөн 8 санал, 100 хувиар буюу 24,500,087 ширхэг хувьцаа;
Татгалзсан санал байхгүй;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнийг сонгох тухай 3-р асуудалд ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс;
 1. Ц. Баяр-Эрдэнэ 24,500,082 хувьцааны санал;
 2. Б. Төрбат 24,500,092 хувьцааны санал;

С.Нямбаяр, хурлын дарга: 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолыг уншиж танилцуулан хурлыг хаав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
 - Компанийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо нийт 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг болохыг дурдав.
 - Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нийт 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг болгон нэмэгдүүлэв.
 - Компанийн одоогийн гаргасан 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон нээлттэй арилжаалахаар нэмж гаргав.
 - Энэхүү шийдвэрийн дагуу нэмж гаргаж буй 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг энгийн хувьцааны 30.31 хувьтай тэнцэх бөгөөд нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгов.
 - Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн зарчмыг баримтлан компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэв.
 - Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нэмж хувьцаа гаргахгүй байхаар тогтов.
 - Компанийн нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 (зургаа) сарын хугацаанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр тусгаарлуулж, арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээх нөхцөлтэй болохыг дурдав.
 - Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах, хувьцаа нэмж гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн хуралд тайланг танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Баяр-Эрдэнэ)-д олгов.
 - Нэмж хувьцаа гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой компанийн дүрэм, энэхүү тогтоолд тухайлан заагаагүй бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгов.
 - Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох, хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас зөвшөөрсний хүрээнд хувьцааны анхдагч арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг хавсралтаар батлав.


- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.
- 2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
 - Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
 - Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.
- 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгов.
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ерийн гишүүнээр Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг сонгов.
 - a. Т.Лхагвасүрэн, Г.Эрдэнэбулган нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
 - b. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

ТАНИЛЦСАН:



С.НЯМБАЯР, ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2023 оны 10 дугаар сарын 12
Улаанбаатар хот.